



АШИГТ МАЛТМАЛ,
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

Эрдэл оны 28 сарын 01. өдөр

Дугаар А/14.

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, 47 дугаар зүйлийн 47.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ашигт малтмал, газрын тосны газрын Техник үйлчилгээний төв, УУГТТЛабораторийн байранд харуул, хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх аж ахуйн нэгж байгууллагыг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: ГҮҮКХ-ийн ахлах мэргэжилтэн Б.Тамир

Нарийн бичгийн дарга : ХШҮСХ-ийн мэргэжилтэн Ц.Содцэцэг

Гишүүд: ТЗҮХ-ийн үйлчилгээ, аж ахуй хариуцсан ажилтан Ж.Доржсүрэн

“Инноваци саруул гэрэлт ирээдүй” ТББ-ын
гишүүн Х.Мөнгөн /зөвшилцсөнөөр/

“Монгол био төсөл” ТББ-ын менежер
Г.Алтаймаа /зөвшилцсөнөөр/

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо /Б.Тамир/-нд үүрэг болгосугай.

3. Үнэлгээний хороонд ажиллах төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн төлөөлөлд Сангийн сайдын 2014 оны 212 дугаар тушаалын дагуу урамшуулал олгохыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /Б.Дашпүрэв/-т даалгасугай.

ДАРГА

Х.ХЭРЛЭН

Хөтлөх хэргийн 4/1-д
Д.Эрдэнэчимэг

Tushaal/A/ D:\SCAN FILES\2021 tushaal

53710321